

SMG SERVICES

Үйлчилгээний нөхцөл

Хүчинтэй болж эхлэх хугацаа: 2018 оны гуравдугаар сар

Эдгээр Үйлчилгээний Нөхцөл ба SMG-ийн Нууцлалын Бодлогын ("**Нөхцлүүд**") нь Service Management Group, LLC ба түүний салбарууд ("**SMG**" эсвэл "бид" буюу "бидний") танд вэбсайт, үйлчилгээ, гар утасны апп болон програмуудыг ашиглах боломж олгох ерөнхий нөхцөлийг тайлбарласан бөгөөд эдгээр нөхцөлийг (хамтад нь "**SMG Services**") гэнэ.

SMG Services-т нэвтрэх, ашиглахаасаа өмнө эдгээр Нөхцөлийг анхааралтай уншаарай; эдгээр нь таны SMG-тэй тогтоох хууль ёсны зөвшилцлийг бүрдүүлдэг.

SMG-ИЙН АЛИВАА ҮЙЛЧИЛГЭЭГ ХЭРЭГЛЭХДЭЭ, ТА ЭДГЭЭР НӨХЦӨЛИЙГ ЗӨВШӨӨРЧ, НӨХЦӨЛҮҮДИЙГ ГҮЙЦЭТГЭХ ХУУЛЬ ЁСНЫ ЭРХТЭЙ БОЛОХЫГ ҮҮГЭЭР БАТАЛЖ БАЙНА. ХЭРЭВ ТА ӨӨРИЙН АЖИЛ ОЛГОГЧИЙН ӨМНӨӨС SMG SERVICES-Г ХЭРЭГЛЭЖ БАЙГАА БОЛ, ЭНЭХҮҮ НӨХЦӨЛ НЬ ТАНЫ АЖИЛ ОЛГОГЧ БА SMG-ИЙН ХООРОНД БАЙГУУЛСАН ЗӨВШИЛЦӨЛ ГЭЖ ТООЦОГДОХ БА ТА АЖИЛ ОЛГОГЧОО ТӨЛӨӨЛЖ ЭНЭ НӨХЦӨЛИЙГ ХУУЛИЙН ДАГУУ ДАГАЖ МӨРДҮҮЛЭХ БҮРЭН ЭРХТЭЙ ГЭДГЭЭ БАТАЛЖ БАЙНА.

ЧУХАЛ ТЭМДЭГЛЭГЭЭ: Эдгээр Нөхцөл нь таны өмнө бидний хүлээх хариуцлагын хэм хэмжээг тодорхойлсон заалтуудыг агуулж буй бөгөөд бидний дунд аливаа маргаан гарсан тохиолдолд та арбитрын шүүхээр асуудлыг шийдвэрлүүлэх ба ийнхүү гаргасан шийдвэр нь эцсийн байхаас гадна шийдвэрийг заавал дагаж мөрдөнө, ингэхдээ аливаа хамтын нэхэмжлэл эсвэл төлөөлөн нэхэмжлэл гаргалгүйгээр, хувь хүний зүгээс шийдүүлэхийг танаас шаардана. Доор байгаа "ГЭРЭЭНИЙ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БАЙДАЛ, БАТАЛГААГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ БА ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГА"(Бүлэг 7) ба "МАРГААНЫГ ШИЙДЭХ" (Бүлэг 9)-ээс дэлгэрэнгүй мэдээллийг үзнэ үү.

ХЭРЭВ ТА ЭНЭХҮҮ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ БА SMG-ИЙН НУУЦЛАЛЫН БОДЛОГОД ТАВИГДСАН БҮХ НӨХЦӨЛИЙГ ЗӨВШӨӨРӨХГҮЙ БОЛ SMG SERVICES-ИЙГ АШИГЛАХ БОЛОМЖГҮЙ.

1. НӨХЦӨЛД ОРУУЛСАН ӨӨРЧЛӨЛТ

Эдгээр Нөхцөлийн хүчин төгөлдөр болох огноог энэ вэб хуудасны дээд хэсэгт заасан болно. Бид шинэ зүйлүүд нэмэхийн хирээр эдгээр Нөхцөлийг өөрчлөх болно. SMG нь Нөхцөлүүдийг шинэчлэн эдгээр Нөхцөлийг хэзээ ч өөрчилж болно. Та гарсан бүх өөрчлөлтийг заавал дагаж мөрдөх ёстой; иймд та энэ хуудсаар үе үе орж, Нөхцөлүүдийг судалж байх хэрэгтэй. Өөрчлөгдсөн нөхцөлийг байрлуулсны дараа та SMG үйлчилгээг үргэлжлүүлэн ашигласаар байвал нэмэлт өөрчлөлт бүхий Нөхцөлийг хүлээн зөвшөөрсөнд тооцно. Нэмэлт өөрчлөлт бүхий Нөхцөлүүд нь гэрээний өмнөх хувилбарууд, Нөхцөлийн

тухай мэдэгдэл эсвэл тэмдэглэлийг орлох боловч өөрчлөлт орсноос өмнөх хувилбарт хамаарахгүй.

2. НЭМЭЛТ НӨХЦӨЛ

SMG Services-ээр дамжуулан санал болгодог зарим үйлчилгээ, тухайлбал мобайл програмууд, сугалаа, санал, уралдаан ба бусад үйлчилгээ нь тэдгээртэй холбоотойгоор оруулсан нэмэлт нөхцөл, журмаар зохицуулагдаж болно ("Нэмэлт нөхцөл"). Та ийм үйлчилгээг ашиглахаасаа өмнө Нэмэлт нөхцөлийг зөвшөөрөх ёстой. Аливаа Нэмэлт нөхцөл оруулахдаа эдгээр Нөхцөлд нэмэлт болгож оруулна. Хэрэв Нэмэлт нөхцөлийн аль нэг заалт эдгээр Нөхцөлийн аль нэг заалттай зөрчилдвөл, Нэмэлт нөхцөл нь зөвхөн зөрчилдөж буй заалтын хувьд л энэ Нөхцөлөөс давуу эрхтэй байна.

3. НУУЦЛАЛ / АЮУЛГҮЙ БАЙДАЛ

SMG Services-ийг хэрэглэхээсээ өмнө, SMG Services -р дамжин SMG-ийн цуглуулдаг хувийн мэдээлэл, мэдээллийг хэрхэн боловсруулдаг болон хувийн мэдээллийг хэнтэй хуваалцдаг талаар мэдээлэл бүхий SMG-ийн Нууцлалын Бодлогыг анхааралтай уншина уу. SMG-ийн Нууцлалын Бодлогын хувийг та доорх хаягаар орж уншиж болно:

4. SMG КОНТЕНТ

SMG Services -р дамжуулж буй аливаа мэдээлэл, график, дүрс, урлагийн бүтээл, бичвэр, видео клип, өгөгдлийн багц, програм хангамж, аудио клип, худалдааны тэмдэг, үйлчилгээний тэмдэг, бүртгэл, худалдааны нэр ба бусад контентийг (хамтад нь "**SMG Контент** ") SMG, манай салбар компаниуд, түншүүд, лиценз эзэмшигчид болон төлөөлж буй компаниуд эзэмшдэг бөгөөд АНУ ба гадаадын зохиогчийн эрх, барааны тэмдгийн патент, бусад хууль тогтоомжоор хамгаалагдана. Доорх хязгаарлагдмал нөхцөлтэй лицензид тусгаснаас өөрөөр, эсвэл холбогдох хуулийн дагуу шаардлагатай бус бол, биднээс урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр зохиогчийн эрх, барааны тэмдэг, бусад оюуны өмч болон SMG Services-ийн аль ч хэсгийг хэрэглэх, хуулбарлах, хувилах, олшруулах, зарах, дахин зарах, хүртэх, өөрчлөх, эсвэл аливаа зорилгоор бүрэн ба хэсэгчлэн, өөр замаар ашиглахыг хориглоно. SMG Контентийг зөвшөөрөлгүй хэрэглэх нь зохиогчийн эрх, худалдааны тэмдэг болон бусад хуулийг зөрчиж буй явдал юм.

Хэрэв та эдгээр Нөхцөлийг (мөн тухайн SMG Контентод хамааралттай нэмэлт нөхцөл ба болзлыг) зөвшөөрч байгаа бол SMG танд SMG Services-ийг зөвхөн өөрийн хувийн хэрэгцээнд зориулан эдгээр Нөхцөлийн хүрээнд хэрэглэх ба татаж авах, хэвлэх ба/эсвэл хуулах хувийн, буцааж авах эрхтэй, онцгой бус, дамжуулж болохгүй хязгаарлагдмал лицензийг (дэд лиценз буюу цааш өөр хүнд олгох эрхгүй) олгож байна. SMG Services-д агуулагдах худалдааны нууц болон оюуны өмчийн эрхийг танд олгоогүй буюу ямарваа нэг хэлбэрээр танд задлаагүй гэдгийг та хүлээн зөвшөөрч байна. SMG Үйлчилгээ-ний хуудсуудыг үүсгэх зорилгоор бүтээж буй HTML код нь SMG-ийн зохиогчийн эрхээр хамгаалагдсан гэдгийг та хүлээн зөвшөөрч байна. Энд тодорхойлон тусгаагүй бүх эрхийг SMG хадгалан үлдэнэ.

SMG танд урьдчилан бичгээр зөвшөөрөл олгоогүй тохиолдолд та дараах зүйлсийг хийхгүй болохыг хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- a. бусад аливаа ажилд (жишээ нь таны өөрийн вэбсайт) SMG контентыг оруулах эсвэл SMG контентыг олон нийтэд ашиглуулах эсвэл арилжааны хэлбэрээр ашиглах;
- b. SMG контентийн хэсэг байж болох зохиогчийн эрх, худалдааны тэмдэг, оюуны өмчийн эрхийн аливаа мэдэгдлийг өөрчлөх; эсвэл

с. SMG-ийн аль нэг үйлчилгээний "deep link" (ө.х., SMG Services-ийн нүүр хуудсаас бусад үйлчилгээний хуудас руу орох холбоос) буюу "гүн холбоос" бий болгох. SMG Services эсвэл түүгээр дамжуулан хэрэглэж буй худалдааны тэмдэг, лого, үйлчилгээний тэмдгүүд нь ("Тэмдэг") SMG эсвэл гуравдагч этгээдийн эзэмшилд байдаг. SMG эсвэл гуравдагч этгээдээс урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр Тэмдгийг ашиглахыг хориглоно. SMG Контентыг ашиглах зөвшөөрлийг SMG-ээс хэрхэн авах тухай мэдээлэл авахыг хүсвэл privacyofficer@smg.com руу имэйлдэнэ үү.

5. SMG SERVICES-ИЙГ ХЭРЭГЛЭХ НЬ

5.1. Тавигдах шаардлага: SMG үйлчилгээ нь тухайн оршин сууж буй улсын хуулийн дагуу хувийн мэдээллээ боловсруулалтад оруулах зөвшөөрөл өгөх насанд хүрээгүй хүүхдэд зориулагдаагүй болно. Хэрэв та танай улсад зөвшөөрсөн насанд хүрээгүй бол SMG-ийн үйлчилгээг ашиглаж болохгүй.

5.2. Таны Бүртгэл: SMG үйлчилгээг ашиглахын тулд бүртгэлийн данс ("Бүртгэл") үүсгэх шаардлагатай. Та өөрийн тухай бүрэн, зөв, хамгийн сүүлийн үеийн мэдээллийг өгнө, хадгална, мөн шаардлагатай бол мэдээллийг шинэчилнэ гэдгээ зөвшөөрч байна. Аливаа хүн эсвэл байгууллагын оронд оролцохгүй, өөр хүний хэрэглэгчийн нэр, нууц үг болон бусад бүртгэлийн мэдээлэл, эсвэл өөр хүний нэр, дүрс, дуу, зураг, гэрэл зургийг оролцуулан, өөрийн бие хүн, байгууллагын харьяаллыг хуурамчаар мэдүүлэхгүй гэдгээ зөвшөөрч байна. Цаашилбал, хэрэглэгчийн нэр, нууц үг, бусад бүртгэлийн мэдээллийг зөвшөөрөлгүй хэрэглэсэн, эсвэл SMG Services-д хамааралтайгаар аюулгүй байдал зөрчигдсөнийг та мэдсэн бол энэ тухай privacyofficer@smg.com хаягаар бидэнд мэдэгдэхээ та зөвшөөрч байна.

Бүртгэл үүсгэснээр SMG нь таны дансыг идэвхжүүлэхийн тулд таны өгсөн имэйл хаягийг ашиглан тантай холбогдохыг та зөвшөөрч байна.

Таны дансыг ашиглахыг бусдад бүү зөвшөөр. Та өөрийн дансны бүх ашиглалт, мөн дансанд орох зөвшөөрөл танаас авсан бусад хүмүүсийн ашиглалтыг та хариуцах ёстой.

5.3. Таны Хариуцлага:

Зөвхөн хууль ёсны зорилгоор SMG Services-г ашиглана. Та SMG Services-г зөвхөн хууль ёсны зорилгоор ашиглах болно гэдгийг зөвшөөрч байна. Та SMG-ийн серверүүд ба сүлжээг гэмтээх, эвдэх, хэт ачаалах, хохирол учруулах байдлаар SMG Services-г хэрэглэхгүй, эсвэл бусад хүний SMG-гийн хэрэглээ болон тав тухад саад болохгүй.

Хууль бус ба зөвшөөрөгдөөгүй зорилгоор SMG Services-ийг ашиглахгүй. Цаашилбал та, SMG Services, бусад хэрэглэгчийн данс ба SMG-ийн компьютерийн систем, сүлжээг хакердах, нууц үг олох болон бусад аргаар зөвшөөрөлгүй нэвтрэх арга хэрэглэхгүй гэдгийг зөвшөөрч байна. Дээр дурдсан зүйлсийн аль нэгийг хязгаарлалгүйгээр, та дараах зүйлсийг хийхгүй (мөн та гуравдагч этгээдээр дараах зүйлсийг хийлгүүлэхгүй) гэдгийг зөвшөөрч байна:

- a. хуулбарлах, өөрчлөх, тохируулах, хөрвүүлэх, урвуу инженерчлэх, кодыг тайлах болон өөр аргаар SMG Services эсвэл SMG Контентын аль нэг хэсгийг олж авах буюу нэвтрэхийг оролдох;
- b. SMG Services эсвэл SMG Контентод агуулагдсан аливаа зохиогчийн эрх, худалдааны тэмдэг эсвэл бусад өмчийн эрхийн мэдэгдлийг арилгах;
- c. Манай Үйлчилгээ ба SMG Контентийн хэрэглээ, хуулбарлалтыг хязгаарлах, эсвэл хэрэглээний хязгаарлалтыг сахиулдаг аюулгүй байдал буюу залилангаас урьдчилан сэргийлэхтэй холбоотой тохиргоог тойрч гарах арга хайх, эвдэх, эсвэл өөр байдлаар саад учруулах;
- d. вирус, Троян, өт, логик бөмбөг, тагнуулын програм, хортон, бусад хортой буюу технологийн хор хөнөөлтэй материалыг зориуд оруулан манай Үйлчилгээг зүй бусаар ашиглах;
- e. робот, аалз, сайтын хайлт/ сэргээлтийн програм, бусад автоматжуулсан төхөөрөмж, процесс, хэрэгслийг SMG үйлчилгээний аливаа хэсэгт хандах, гаргаж авах, арилгах, индексжүүлэхэд хэрэглэх;
- f. SMG Services ба SMG Services-ийн онцлог эсвэл функцийг түрээслэх, хөлслүүлэх, зээлдүүлэх, зарах, лиценз дамжуулах, хуваарилах, түгээх, нийтлэх, шилжүүлэх замаар ямар нэг шалтгаанаар гуравдагч этгээдэд хүргэх, SMG Services-ийг нэгээс илүү төхөөрөмж хандах боломжтой сүлжээнд оруулах;
- g. SMG Services-ийн хэсэг болох вэб хуудасны аливаа хэсгийг дахин форматлах, эсвэл хүрээлэх;
- h. худал эсвэл залилангийн аргаар нэгээс дээш данс автоматаар үүсгэх; эсвэл
- i. хэрэглэгчээс бичгээр зөвшөөрөл авалгүйгээр аливаа хэрэглэгчийн хувийн мэдээллийг цуглуулах буюу хадгалах.

SMG Services-ийг зөвшөөрөлгүй эсвэл зүй бусаар ашигласны үр дагавар. Эдгээр дүрмийн аль нэгийг зөрчсөн даруйд таны SMG Services-ийг ашиглах эрхийг зогсоож, хэрэв та энэ Нөхцөл ба холбогдох нэмэлт Нөхцөлд заасан шаардлага ба хоригуудыг зөрчвөл, SMG өөрийн үзэмжээр, сануулга өгөлгүйгээр SMG Services-д нэвтрэх таны эрхийг цуцлах эрхтэй гэдгийг та зөвшөөрч байна. Хэрэв бид танаас шаардсан бол, та сайтаас хувилж авсан аливаа материалыг буцаан өгч, устгахыг зөвшөөрнө.

SMG Services-ийг зөвшөөрөгдөөгүй байдлаар, зүй бусаар ашиглахыг хатуу хориглоно; нөхцөл байдлаас шалтгаалан, хохирол учруулсны төлөө танд иргэний ба/эсвэл эрүүгийн хариуцлага хүлээлгэх нэхэмжлэл гаргаж болно. SMG нь эдгээр Нөхцөлийг зөрчсөн, эсвэл SMG Services-ийг зөвшөөрөгдөөгүй байдлаар, зүй бусаар ашигласан бол хууль сахиулах байгууллагад мэдээлэх эрхтэй. SMG Services-ийг зөвшөөрөгдөөгүй байдлаар, зүй бусаар ашигласан тохиолдолд, таны SMG Services-ийг ашиглах эрх нэн даруй хаагдах бөгөөд SMG нь урьдчилан мэдэгдэлгүйгээр SMG Services-д хандах боломжийг хааж болно.

SMG Services-ийг ашиглахтай холбоотой төлбөр, хураамж болон бусад зардлыг хариуцах тухай (үүнд текст мессежийн төлбөр орно). SMG Services-ийг ашиглахтай холбоотой бүх төлбөр, хураамж болон бусад зардлуудыг та өөрөө хариуцна. Хэрэв та ухаалаг утас, таблет эсвэл бусад хөдөлгөөнт төхөөрөмж дээр SMG Services-т нэвтэрч ашигладаг бол та Wi-Fi эсвэл оролцогч мобайл үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулан утасгүй үйлчилгээ авах ёстой. Зарим үйлчилгээг авахын тулд текст мессеж ашиглах (SMS эсвэл MMS) шаардлага гарч болно. Та мобайл үйлчилгээ үзүүлэгчээсээ авсан бүх мессеж, өгөгдлийн төлбөрийг өөрөө хариуцна гэдгээ хүлээн зөвшөөрч байна. Бид танд явуулдаг аливаа текст мессежийн үйлчилгээнд тусад нь төлбөр ногдуулахгүй боловч мессеж болон интернет ашигласны төлбөр гарч болно. Таны мобайл үйлчилгээ үзүүлэгч байгууллага бүх төлбөрийн тооцоог явуулж,

төлбөрийг хүлээж авна. Мобайл үйлчилгээ үзүүлэгчтэйгээ холбогдож, үйлчилгээний багцын үнэ болон дэлгэрэнгүй мэдээллийг аваарай. Текст мессежийг хүргэхэд удаашрал гарах, эсвэл текст мессежийг хүргэх боломжгүй бол SMG хариуцлага хүлээхгүй, учир нь мессеж хүргэлт нь таны мобайл үйлчилгээ үзүүлэгчийн дамжуулалтын чадвараас хамаардаг. Текст мессежийн үйлчилгээ зарим газарт, зарим үед байхгүй байж болно.

Та текст мессеж хүлээн авах сонголт хийснээр дараах нөхцөл үйлчилнэ. Үүнд: Та биднээс текст мессеж хүлээн авах сонголт хийсэн бол бидний илгээх текст мессежийн давтамж нь бидэнтэй хийсэн таны гүйлгээнээс хамаарна. **Текст мессеж хүлээн авахыг зөвшөөрснөөр SMG нь танд текст мессеж илгээхдээ автоматаар залгагдах системийг ашиглаж болох бөгөөд цаашилбал, та ямар нэгэн бараа, үйлчилгээ худалдан авахын тулд текст мессеж хүлээн авах зөвшөөрөл өгөх шаардлагагүй гэдгийг ойлгож байна.**

- 5.4. Материал явуулах. SMG танд болон бусад хэрэглэгчдэд үнэлгээ, санал, видео комент, санаа, тэмдэглэл, ухагдахуун эсвэл бусад мэдээлэл, материалыг (нийтэд нь "Материал") сайн дурын үндсэн дээр SMG Services-т эсвэл түүгээр дамжуулан явуулахыг санал болгодог.

Явуулсан Материал болон ийм Материал илгээж, байрлуулсны үр дагаврыг та өөрөө хариуцах бөгөөд хэзээд ч хариуцах болно. Таны явуулсан Материалаас үүдэлтэй, зохиогчийн эрх, өмчлөх эрхийг зөрчсөн, эсвэл аливаа бусад хор хохирол учирсны хариуцлагыг та өөрөө хүлээх болно. Материал явуулах эсвэл нийтлэхдээ өөрийн хувийн мэдээллийг аль болох оруулахгүй байхыг хичээх хэрэгтэй. Учир нь та хэр их хэмжээний хувийн мэдээлэл оруулсанаас хамааран Материалыг тантай холбох боломжтой.

SMG (ба/эсвэл бидний төлөөлөгчид) эсвэл SMG Services-ийн аль ч хэсэг рүү Материал илгээж, нийтэлж, дамжуулснаараа та болон материалын бусад эзэмшигч нь SMG ба бидний төлөөлөгчдөд Материалыг дэлхий даяар, онцгой бусаар, дэд лицензээр тараах (хэд хэдэн үе шатаар), дамжуулах, ашигласны төлбөргүй, хугацаагүй, буцалтгүй байдлаар, тарааж болох байдлаар, дуурайсан бүтээгдэхүүн гаргах, одоогоор мэдэгдэж байгаа болон цаашид гарч болох аль ч мэдээллийн хэрэгсэлд, худалдааны болон бусад аль ч зорилгоор Материалыг хэрэглэх ба импортлох бүрэн эрх олгох ба ингэснээр танд мөнгө төлөхгүй. Өөрөөр хэлбэл, SMG таны оруулсан Материалыг хувилах, дэлгэх, нийтлэх, эсвэл мэдээллийн хэрэгслээр цацах зэргээр хаана ч, ямар ч үед, ямар ч зорилгоор, танд төлбөр хураамж төлөлгүйгээр эсвэл таны өмнө ямар нэг үүрэг хүлээлгүйгээр автоматаар ашиглах эрхтэй болно. Мөн таны Материалд нэвтрэх, харах, хадгалах эсвэл хувийн хэрэглээндээ зориулан хувилахыг бусад хэрэглэгчид та зөвшөөрнө. Та үүгээр SMG-д (ба/эсвэл манай томилсон хүмүүст) таны аль ч Материалыг ямар нэг зорилгоор хаана ч ашиглах эрхийг олгож байна. SMG (ба/эсвэл түүний томилсон хүмүүс) таны Материалын аль нэгийг ашиглахад та ямар ч нөхцөлд ямар нэгэн төлбөр авах эрхгүй. Бүх Материал нь нууц бус, хэн нэгний өмч бус хэмээн тооцогдоно.

Таны илгээсэн Материалыг олон нийтэд нээлттэй байдлаар байрлуулж болно. Цаашилбал, таны явуулсан аль ч Материалд хувийн нууцлалын асуудал хамаарахгүй гэдгийг та хүлээн зөвшөөрч байна. Та Материалаа сайн дурын үндсэн дээр, өөрийн эрсдэлийг ойлгож ухамсарласан байдлаар оруулна гэдгийг хүлээн зөвшөөрч байна. SMG, SMG-ийн үйлчлүүлэгчид болон бусад байгууллага, хувь хүнтэй холбоотой

мэдээлэл, хэлсэн үг, эсвэл бусад агуулгыг нийтлэхдээ эрүүл ухаанаар хандах хэрэгтэй. Таны зүгээс гүтгэлэг бүхий эсвэл хуулийн хариуцлага тооцож болох Материал илгээсний улмаас бусад хэрэглэгчид, SMG, эсвэл гуравдагч этгээдэд хохирол учирвал та хуулийн хариуцлага хүлээх болно. Хэрэв таны оршин сууж буй улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол, та Материалаа нийтэлж байхдаа Материалыг өөрийн хэрэглэгчийн нэр эсвэл нууц нэртэй холбохоор сонгож болно.

SMG нь хэрэглэгчийн хийсэн аливаа Материал, тэр ч байтугай нэр төр гутаасан эсвэл хуулийн хариуцлага тооцож болох Материалтай холбоотойгоор хуулийн хариуцлага хүлээхгүй. SMG нь SMG Services-т болон түүгээр дамжуулан нийтэлсэн сэтгэгдэл, санал, зөвлөгөө, зөвлөмж зэрэгтэй холбоотойгоор хариуцлага хүлээхгүй бөгөөд тэдгээрийг нийтлэх зөвшөөрөл олгодоггүй. SMG нь ялангуяа ийм Материалтай холбоотой аливаа болон бүхий л хариуцлагаас татгалзана. SMG нь хэрэглэгчдийн мэдлэг, чадвар, боловсрол болон тэдний SMG Services-ээр дамжин болон шууд нийтэлсэн мэдээллийг баталгаажуулахгүй ба үнэн зөвийг нягтлахгүй. Тиймээс та явуулах Материал бэлтгэхдээ нийтлэг мэдрэмж, эрүүл ухаанаар хандахыг SMG зөвлөж байна.

Материал нийтлэхдээ та уг Материал нь дараах шинж чанартай байна гэдгийг зөвшөөрч, баталж байна. Үүнд:

- a. үнэн зөв;
- b. SMG үйлчилгээний талаархи сэдэв эсвэл агуулгатай холбоотой;
- c. гуравдагч этгээдийн зохиогчийн эрх, худалдааны тэмдэг, патент, утга зохиолын, худалдааны нууц, хувийн нууц, сурталчилгаа, өмчийн, гэрээний болон бусад эрхэнд халдахгүй, хууль бусаар эзэмдэхгүй, зөрчихгүй байх;
- d. тухайн хүний урьдчилан бичгээр өгсөн зөвшөөрөлгүй бол ; тухайн хүнийг танихуйц мэдээлэл эсвэл хувийн мэдээллийг агуулаагүй;
- e. аливаа гуравдагч этгээд, түүний бүтээгдхүүн буюу үйлчилгээний талаар нотолгоогүй нэхэмжлэл үүсгэхгүй;
- f. ямарваа гүтгэсэн, нэр төр гутаасан, худал, төөрөгдүүлсэн, бүдүүлэг, шалиг, садар самуун, хүчирхийлэлтэй, ялгаварласан, завхай, үзэн ядсан, доромжилсон, заналхийлсэн, дарамталсан, бэлгийн болоод арьс өнгөний хувьд дайрч доромжилсон тайлбар агуулаагүй, эсвэл аливаа хүн буюу байгууллагад хохирол учруулах болон хохирол учруулах магадлалтай контент агуулаагүй;
- g. хууль бус биш бөгөөд хууль бус үйл ажиллагааг дэмжихгүй, хамгаалахгүй, хууль бус үйл ажиллагаа явуулах зорилгоор хэлэлцэж ярилцахгүй байх;
- h. арилжааны бус, бизнестэй холбоотой биш бөгөөд аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээг (ашгийн бус болон ашгийн төлөө) зарж сурталчлах эсвэл бусдад санал болгохгүй (тусламж, хандивыг оруулаад);
- i. вирус буюу бусад хортой бүрэлдэхүүн хэсгийг агуулаагүй, эсвэл өөр байдлаар SMG Services буюу аливаа холбогдсон сүлжээнд хөндлөнгөөс саад учруулахгүй, гэмтээхгүй, эсвэл SMG Services-ийг хэрэглэх, таашаахад нь аливаа хүн ба байгууллагад саад болохгүй; ба
- j. Насны хязгаарлалтыг оруулаад, таны ирүүлсэн Материалд болон таны илгээж буй буюу дамжуулан нийтэлж байгаа SMG Services-д холбогдох бүхий л хууль, журам, дүрэм, бодлого болон гэрээний нөхцөлд нийцсэн.

SMG нь ямар ч Материалыг өөрчлөх, хасах эсвэл нийтлэхээс татгалзах эсвэл нийтлэхийг зөвшөөрөх эрхтэй боловч тийм үүрэг хүлээхгүй гэдгийг та хүлээн зөвшөөрч

байна. Таны эсвэл бусад гуравдагч этгээдийн нийтэлсэн Материалтай холбоотойгоор SMG ямар ч үүрэг хариуцлага хүлээхгүй. SMG нь хэрэглэгчид эдгээр заалтыг дагаж мөрдөх явдлыг хариуцахгүй бөгөөд заалтуудыг дагаж мөрдөөгүйгийн улмаас та болон SMG-ийн дунд гарсан хохирол, алдагдлын эрсдэлийг та өөрөө хариуцах болно.

Материалдаа хувийн мэдээлэл аль болох бага оруулахыг SMG танд чухалчлан зөвлөж байна. Учир нь бусад хүмүүс таны оруулсан Материалаас хувийн мэдээллийг харж, ашиглах боломжтой. SMG нь таны Материалаар дамжуулан оруулсан мэдээлэлтэй холбоотой хариуцлага хүлээхгүй.

6. Гуравдагч этгээдийн сайтууд ба үйлчилгээ

SMG Services нь гуравдагч этгээдийн вэбсайт, үйлчилгээ, тухайлбал, нийгмийн сүлжээний (нийтэд нь "Холбоостой үйлчилгээ") холбоосыг агуулж болно. Холбоостой үйлчилгээ нь SMG-ийн хяналт дор байдаггүй бөгөөд SMG нь Холбоостой үйлчилгээ эсвэл ямар нэгэн Холбоостой үйлчилгээнээс хүлээн авсан аливаа мэдээлэл, материалыг хариуцахгүй. Холбоосыг оруулах нь SMG Холбоостой үйлчилгээг дэмждэг, эсвэл Холбоостой үйлчилгээний операторуудтай ямар нэгэн холбоо хамааралтай гэсэн үг биш юм. SMG нь Холбоостой үйлчилгээг шалгах, баталгаажуулах эсвэл хянах үйл ажиллагаа явуулахгүй. SMG нь зөвхөн таны тав тухыг бодож Холбоостой үйлчилгээний холбоосыг өгдөг. Та өөрийн эрсдэлээр Холбоостой үйлчилгээнд нэвтэрнэ.

7. ГЭРЭЭНИЙ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БАЙДАЛ, БАТАЛГААГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ БА ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГА

SMG нь эдгээр Нөхцлийг хууль ёсны дагуу тодорхойлсон ба заасан нөхцөлүүдийг гүйцэтгэх хууль ёсны эрхтэй болохыг SMG үүгээр баталж байна. Та эдгээр Нөхцлийг хууль ёсны дагуу хүлээн зөвшөөрсөн ба заасан нөхцөлүүдийг гүйцэтгэх хууль ёсны эрхтэй болохыг үүгээр баталж байна.

ДЭЭР ТОДОРХОЙ ЗААСНААС БУСАД ТОХИОЛДОЛД, SMG SERVICES НЬ “БАЙГААГААР НЬ”, “НЭВТРЭХ БОЛОМЖООР НЬ” ЯМАР НЭГ ТОДОРХОЙ БА БОЛЗОЛТ БАТАЛГААГҮЙГЭЭР ҮЙЛЧИЛНЭ.

SMG нь SMG Контентийн үнэн зөв, найдвартай, бүрэн дүүрэн, цаг үеийн байх явдал зэргийг хариуцахгүй, мөн SMG Services болон SMG Контентийг ашиглан олж авах үр дүнгийн тухайд ямар нэгэн төлөөлөл, баталгаа гаргахгүй. Та өөрийн эрсдэлээр SMG Services болон Контентийг хэрэглэнэ. SMG Services болон SMG Контент-д үе үе өөрчлөлт хийгддэг. Эдгээр өөрчлөлтийг хэзээ ч хийж болно. SMG Services хүрээнд зарим агуулгыг гуравдагч этгээдээс авсан байж болно. SMG нь гуравдагч этгээдийн агуулгатай холбоотой хариуцлага хүлээхгүй.

ЯМАР Ч ТӨРЛИЙН ЯМАР Ч БАТАЛГАА ГАРГАЛГҮЙГЭЭР “БАЙГААГААР” НЬ ГЭСЭН ЗАРЧМААР SMG SERVICES-Г ҮЗҮҮЛЖ, SMG КОНТЕНТИЙГ ОЛГОНО. SMG НЬ ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗӨВШӨӨРЧ БҮЙ ХАМГИЙН ДЭЭД ХЭМЖЭЭГЭЭР ЯМАР Ч ТӨРЛИЙН ЯМАР Ч БАТАЛГАА БА НӨХЦӨЛИЙГ ХҮЧИНГҮЙД ТООЦОХ БӨГӨӨД ҮҮНД ХУДАЛДААНЫ БҮХ ЗҮЙ ЁСНЫ БАТАЛГАА, НӨХЦӨЛ, ТОДОРХОЙ ЗОРИЛГО, НЭРШЛИЙН НИЙЦЭЛ, ӨМЧЛӨГЧ ЭСВЭЛ ГУРАВДАГЧ ЭТГЭЭДИЙН ЭРХИЙН ҮЛ ЗӨРЧИЛТ, ДЕФЕКТ, ГОЛОГДОЛГҮЙ БАЙДАЛ, ТАСРАЛТГҮЙ ҮЙЛЧИЛГЭЭ, АЛИВАА

АРИЛЖААНЫ ХАНШ, ХУДАЛДААНЫ ЗОРИУЛАЛТЫН ТАСРАЛТГҮЙ АШИГЛАЛТ, ТЭДГЭЭРЭЭС УРГАН ГАРСАН БҮХ БАТАЛГАА ЗЭРЭГ ОРНО.

SMG НЬ ДАРААХИЙГ БАТЛАХГҮЙ. ҮҮНД: (А) SMG SERVICES ТАНЫ ШААРДЛАГЫГ ХАНГАНА, (В) SMG-ИЙН АЖИЛЛАГАА ТАСРАЛТГҮЙ, ВИРУС ЭСВЭЛ АЛДААГҮЙ БАЙНА, (С) АЛДААГ ЗАСНА. ХЭРЭВ ТА SMG SERVICES ЭСВЭЛ SMG КОНТЕНТИЙГ АШИГЛАСНААР ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИНДӨӨ ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙЛГЭХ ЭСВЭЛ СОЛИХ ШААРДЛАГАТАЙ БОЛСОН ЭСВЭЛ МЭДЭЭЛЛЭЭ АЛДСАН, ЭСВЭЛ АЛДАГДАЛД ОРСОН ТОХИОЛДОЛД SMG НЬ ҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ ГАРЧ БОЛОХ ЗАРДЛЫГ ХАРИУЦАХГҮЙ. SMG ЭСВЭЛ ТҮҮНИЙ ЭРХ БҮХИЙ ТӨЛӨӨЛӨГЧДИЙН АМААР ЭСВЭЛ БИЧГЭЭР ГАРГАСАН АЛИВАА ЗӨВЛӨМЖ НЬ БАТАЛГАА БИШ БӨГӨӨД БАТАЛГАА БОЛОХГҮЙ. ЗАРИМ ГАЗАР ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙНХЭЭ ХҮРЭЭНД ШААРДЛАГАТАЙ БАТАЛГААГ ТООЦОХГҮЙ БАЙХ ЯВДЛЫГ ЗӨВШӨӨРДӨГГҮЙ БӨГӨӨД ИЙМ ТОХИОЛДОЛД ДЭЭРХ БҮХ ЗААЛТ ЭСВЭЛ ЗАРИМ ЗААЛТ ТАНД ХАМААРАХГҮЙ БАЙЖ БОЛНО ГЭСЭН ҮГ ЮМ.

ТА SMG SERVICES-Г АШИГЛАХТАЙ ХОЛБООТОЙ ГАРАХ ЭРСДЭЛИЙГ ӨӨРӨӨ ДААНА. Хэрэв та SMG Services-д, үүнд мөн аливаа SMG Контентод сэтгэл хангалуун бус байгаа бол, SMG Services-ийг ашиглахаа болих нь таны цорын ганц гарц юм.

ТА SMG ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЖ БОЛЗОШГҮЙ ТУХАЙ ӨМНӨ МЭДЭГДЭЖ БАЙСАН Ч, БАТАЛГАА, ГЭРЭЭ, ХАТУУ ХАРИУЦЛАГА, БУРУУ ҮЙЛДЭЛ (ҮҮНД МӨН ТООМЖИРГҮЙ БАЙДАЛ ГЭХ МЭТ) ЭСВЭЛ ХУУЛЬ ЁСНЫ ОНОЛ ДЭЭР ТУЛГУУРЛАСАН ЭДГЭЭР НӨХЦӨЛТЭЙ ХОЛБООТОЙГООР, SMG SERVICES БОЛОН КОНТЕНТИЙГ АШИГЛАХ ЧАДВАРГҮЙН УЛМААС УРГАН ГАРЧ ИРСЭН АЛИВАА ХАРИУЦЛАГЫГ SMG БОЛОН SMG SERVICES-ТЭЙ ХАМААРАЛТАЙ ГУРАВДАГЧ ЭТГЭЭДҮҮД ДАРААХ ЯМАР Ч ТОХИОЛДОЛД ХҮЛЭЭХГҮЙ. ҮҮНД: (А) ШУУД, ШУУД БУС, ОНЦГОЙ, ЖИШЭЭ БОЛОХ, САНАМСАРГҮЙ, ҮР ДАГАВАРТАЙ БОЛОН БУСАД ТӨРЛИЙН ХОХИРОЛ АЛДАГДАЛ (ҮҮНД МӨН ОРЛУУЛАХ БАРАА ЭСВЭЛ ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАЛТ, ХЭРЭГЛЭЭ, ӨГӨГДӨЛ ЭСВЭЛ АШГИЙН АЛДАГДАЛ, БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАСАЛДУУЛАЛТ ХАМААРНА, ГЭХДЭЭ ҮҮГЭЭР ХЯЗГААРЛАГДАХГҮЙ), (В) SMG SERVICES-ИЙГ АШИГЛАХТАЙ ХОЛБООТОЙГООР ҮҮДЭН ЭСВЭЛ УРГАН ГАРЧ ИРЖ БУЙ АЛИВАА НЭХЭМЖЛЭЛ, ШААРДЛАГА, ХОХИРЛЫГ ХАРИУЦАХГҮЙ БОЛНО. ЭНЭХҮҮ ХАРИУЦЛАГЫГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХӨӨС ТАТГАЛЗСАН Ч БИДНИЙ ХАЙХРАМЖГҮЙ БАЙДАЛ ЭСВЭЛ САНААТАЙ БУРУУ ҮЙЛДЛЭЭС ҮҮДЭН ГАРСАН ХАРИУЦЛАГЫГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ БА ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖООР ХОРИГЛОСОН ХЭМ ХЭМЖЭЭНД ЗАХИРАГДАНА.

ХЭРЭВ ЭНЭХҮҮ 7-Р БҮЛЭГТ ЗААСАН БАТАЛГААГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ /БА ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГЫГ ТООЦОХГҮЙ БАЙХ ЗЭРЭГ НӨХЦЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛОМЖГҮЙ БОЛСОН БОЛ SMG-ИЙН УЧРУУЛСАН ХОХИРЛЫГ БАРАГДУУЛАХ ӨР ТӨЛБӨРИЙН ХАМГИЙН ДЭЭД ХЭМЖЭЭ 1000 АМ. ДОЛЛАР ДОТОР БАЙНА.

Дээр заасан хязгаарлагдмал хариуцлага нь эдгээр Нөхцөлийн хязгаарлагдмал хариуцлагын бусад заалтын хамт чухал нөхцөл мөн гэдгийг, түүнчлэн SMG нь эдгээр Нөхцөлд тогтоосон эрхийг танд олгох бус, хязгаарлагдмал хариуцлагыг танаар зөвшөөрүүлэхийг хүсэж байгааг та зөвшөөрч байна.

ХЭРЭВ ТА КАЛИФОРНИ МУЖИЙН ОРШИН СУУГЧ БОЛ ТА КАЛИФОРНИ МУЖИЙН ИРГЭНИЙ ХУУЛИЙН 1542 – Р БҮЛЭГТ ЗААСАН “ЗЭЭЛ ОЛГОГЧ НЬ ӨӨРИЙН ДАВУУ ЭРХИЙГ МЭДЭЖ БАЙСАН БОЛ ЗЭЭЛДЭГЧДЭЭ ӨРИЙГ ЗОХИЦУУЛАХАД НӨЛӨӨЛӨХ

БАЙСАН БОЛОВЧ ДАВУУ ТАЛАА МЭДЭЛГҮЙГЭЭР ЗЭЭЛ ОЛГОСОН БОЛ ЭНЭ НЬ НЭХЭМЖЛЭЛД ХАМААРАХГҮЙ” ГЭСЭН ЭРХЭЭСЭЭ ТАТГАЛЗАЖ БАЙНА.

8. НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХ (ХОХИРОЛ БАРАГДУУЛАХ)

Та SMG ба түүний үйлчлүүлэгчид, захирлууд, албан тушаалтнууд, ажилтнууд болон төлөөлөгчдийг өөрийн зардлаар хамгаалж, нөхөн төлбөр олгож, бүх хохирол, хариуцлага, өргөдөл гомдол, үйлдэл, нэхэмжлэлээс хамгаалж, нөхөн төлбөр олгож, хохиролгүй байлгахыг зөвшөөрнө, үүнд мөн ямар нэгэн хязгаар тогтоолгүйгээр аливаа мөнгөн хохирол, зардал, өмгөөллийн зардал, үүнд мөн (a) та Материал илгээснээс, (b) SMG Services- ийг хэрэглэснээс эсвэл (c) эдгээр Нөхцөлийн аль нэгийг зөрчсөнөөс үүдэн гуравдагч талын зүгээс SMG-д учруулсан өмгөөлөл ба нягтлан бодох бүртгэлийн төлбөр, хураамж зэрэг орно. Энэхүү нөхөн төлбөр олгох тухай заалт нь холбогдох хууль тогтоомжоор хориглосон тэр хэм хэмжээнд үйлчлэхгүй. SMG нь нөхөн төлбөрт хамаарах аливаа асуудалд онцгой хамгаалалт, хяналт тавих эрхийг өөртөө үлдээж, өөрийн зардлаар шийднэ. SMG-ээс урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр SMG-ийн эрх, үүрэгт сөргөөр нөлөөлөх аливаа зохицуулалтыг хийж болохгүй.

9. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

АНУ-ын холбооны хуулиар зохицуулагддаг оюуны өмчийн эрх, үүрэг эсвэл аливаа зөрчлийн талаарх гомдол нэхэмжлэлтэй холбоотой маргааныг эс тооцвол, таны болон SMG-ийн хооронд эсвэл энэхүү Нөхцөлтэй холбоотой аливаа маргааныг, таны харьяаллын орон эсвэл Services-ийг хаана авч байгаагаас үл хамааран, ямар ч зөрчлийн хуулийн зарчмаас үл хамааран, Миссури Мужийн (АНУ) хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ. Ийм төрлийн бүх маргааныг Миссури Мужид байгуулагдан гүйцэтгэгдэж байгаа гэрээнүүдэд хэрэглэдэг Миссуригийн хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ. Энэхүү Нөхцөлийг тайлбарлахад Нэгдсэн Үндэстний Байгууллагын Олон улсын бараа бүтээгдэхүүний худалдааны гэрээний конвенци хамааралгүй болохыг та болон SMG зөвшөөрнө.

ТА БОЛОН SMG НЬ ЗӨВХӨН ХУВИЙН ЖУРМААР НӨГӨӨ ТАЛЫНХАА ЭСРЭГ ГОМДОЛ ГАРГАХ БОЛОМЖТОЙ БӨГӨӨД АЛИВАА БҮЛГИЙН НЭХЭМЖЛЭЛ ЭСХҮЛ ТӨЛӨӨЛӨН НЭХЭМЖЛЭЛ ЗЭРЭГТ НЭХЭМЖЛЭГЧ ЭСВЭЛ БҮЛГИЙН ГИШҮҮНИЙ ХУВИАР ОРОЛЦОЖ БОЛОХГҮЙ.

ТА БОЛОН SMG НЬ БҮХ ГОМДЛОО ЭНЭХҮҮ 9-Р БҮЛЭГТ ЗААСАН АРБИТРИЙН ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛҮҮЛНЭ. ТҮҮНЧЛЭН ШҮҮХЭД ИЙМ ӨРГӨДӨЛ ГОМДОЛ ГАРГАХ ЭРХЭЭСЭЭ ТАТГАЛЗАЖ БАЙГААГАА ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРНӨ. ЭРХ АРБИТРИЙН ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛҮҮЛЭХ ТОХИОЛДОЛД ШҮҮХЭД ХАНДСАН ҮЕД ЭДЛЭХ БОЛОМЖТОЙ ЗАРИМ ЭРХИЙГ ЭДЛЭХГҮЙ ЭСВЭЛ ЭРХ НЬ ХЯЗГААРЛАГДМАЛ БАЙЖ БОЛНО.

Таны болон SMG, түүний агентууд, ажилтнууд, албан тушаалтнууд, захирлууд, дарга нар, өвлөгчид, томилогдогсод, охин компаниуд, салбаруудын хооронд эдгээр Нөхцөлөөс болон тэдгээртэй холбоотойгоор, тэдгээрийн тайлбарлал эсвэл зөрчил, цуцлалт, хүчин төгөлдөр эсэхээс үүдэн гарч ирсэн, түүнчлэн эдгээр Нөхцөлийн хүчин төгөлдөр эсэхийн, үйлчлэх хүрээний талаарх эсвэл эдгээр Нөхцөлийг хамтран маргаан таслахад (хамтдаа холбогдон "Үүссэн Маргаан" хэмээн нэрлэгдэнэ) хэрэглэж болох эсэх талаарх гэх зэрэг эдгээр Нөхцөлийн дагуух харилцаанаас үүдэн гарч ирсэн аливаа маргааныг Миссури мужийн Америкийн Маргаан Таслах Нийгэмлэгийн (American Arbitration Association (AAA)) хүчин төгөлдөр болох огноог нь засан дүрмийн (үүнд мөн хэрэглэгчтэй холбоотой маргаан)-ы дүрэм журмын) дагуу заавал биелүүлэх арбитрарийн хэлэлцээрээр таслана. Хэрэг

таслуулах санаачлагыг гаргаж байгаа тал нь хэрэг таслуулах хүсэлтэй байгаа талаарх мэдэгдлээ нөгөө талдаа дор хаяж 60 хоногийн өмнө урьдчилж бичгээр өгнө. SMG нь ийм мэдэгдлийг таны бүртгэлийн данс үүсгэхдээ заасан цахим шуудангийн хаяг руу, эсвэл таны SMG-д олгосон цахим шуудангийн хаяг руу илгээх болно; таны хувьд ийм мэдэгдлээ privacyofficer@smg.com цахим шуудангийн хаяг руу илгээнэ.

Хэрэг бүртгэл, захиргаа болон арбитрчийн төлбөр, хураамжийг Америкийн Маргаан Таслах Нийгэмлэгийн дүрмээр зохицуулна. Хэрэв та хэрэг таслуулах зардал нь шүүхийн хэлэлцүүлгийн зардалтай харьцуулбал хэт өндөр байгааг нотлон харуулж чадах аваас арбитрч хэрэг таслуулах нь таны хувьд хэр өндөр зардалтай байна гэж үзсэн тэр хэмжээгээрээ SMG-ээр хэрэг бүртгэл, захиргаа болон арбитрчийн төлбөр, хураамжийг төлүүлнэ. Хэрэв арбитрч хэрэг таслах хэлэлцээрт таны мэдүүлж буй гомдол үндэслэлгүй гэж үзсэн тохиолдолд таны нэрийн өмнөөс SMG-ийн төлсөн хэрэг таслахтай холбоотой төлбөр, хураамжийг та буцаан төлөхийг зөвшөөрөх бөгөөд Америкийн Маргаан Таслах Нийгэмлэгийн дүрмийн дагуу төлж барагдуулах үүрэгтэй.

AMTN-ийн Арилжааны Хэрэг Таслах Журмын дагуу нэг арбитрчийг сонгоно. Хэрэг таслах хэлэлцээр Англи хэл дээр явагдана. Арбитрч нь шүүхэд хууль, шударга ёсны дагуу үзүүлэх боломжтой бүхий л дэмжлэг туслалцааг үзүүлэх эрхтэй бөгөөд арбитрчийн гаргасан ямар ч шийдвэр нь талуудын хувьд эцэслэсэн, заавал дагах шийдвэр байхын зэрэгцээ уг шийдвэрийг эрх бүхий ямар ч шүүхийн байгууллагад шийдвэр гэдгээр бүртгэж авах боломжтой. Гэсэн ч арбитрч залхаан цээрлүүлэх буюу торгуулийн хариуцлагыг ногдуулах эрхгүй. Энэ нь хоёр талын аль аль нь татгалзах эрх юм. Арбитрч нь холбогдох хууль болон эдгээр Нөхцөлийн заалтуудыг хэрэглэнэ; үүнийг үл биелүүлсэн тохиолдолд арбитрчийг хэрэг таслах бүрэн эрхээ хэтрүүлсэнд тооцох бөгөөд энэ нь шүүхээр хянан шалгах үндэслэл болно. Арбитрчийн гаргасан шийдвэр нь бичгээр гаргасан тайлбартай бөгөөд нууц байх ёстой. SMG болон та Үүссэн аливаа Маргааныг зөвхөн хувь хувьдаа хэрэг таслуулахаар мэдүүлнэ. **SMG Ч, ТА Ч ҮҮССЭН АЛИВАА МАРГААНЫГ ШИЙДВЭРЛҮҮЛЭХДЭЭ АЛИВАА БҮЛГИЙН, ТӨЛӨӨЛЛИЙН БУЮУ ХУВИЙН ӨМГӨӨЛӨГЧИЙН ҮЙЛДЭЛ МЭТЭЭР ХАНДАЖ БОЛОХГҮЙ БӨГӨӨД АРБИТРЧ БҮЛГИЙН, ТӨЛӨӨЛЛИЙН БУЮУ ХУВИЙН ӨМГӨӨЛӨГЧИЙН ҮНДСЭН ДЭЭР ХЭРГИЙГ ШИЙДВЭРЛЭХ ЭРХГҮЙ.** энэхүү 9-р бүлгийн хэрэг таслах талаарх аль нэгэн заалтыг хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд тухайн заалтыг хүчингүй болгож, хэрэг таслах бусад нөхцөлүүд хэрэглэгдэх боломжтой хэвээрээ байна (гэвч ямар ч тохиолдолд нийгмийн бүлэг, төлөөлөл буюу хувийн өмгөөллөр хэрэг таслуулах боломжгүй). Эдгээр Нөхцөлөөс үүдэн эсвэл түүнтэй холбоотойгоор гарч байгаа аливаа гомдлын тухай мэдэгдлийг хууль тогтоомжид өөрөөр заасан байгаа эсэхээс үл хамааран тийм гомдол үүссэнээс хойш нэг (1) жилийн дотор гаргах бөгөөд эс бөгөөс маргааныг хэзээ ч шийдвэрлэх боломжгүй болно. Энэхүү 9-р бүлгийн зорилгын хувьд эдгээр Нөхцөл болон холбогдох үйл ажиллагаа нь Холбооны Хэрэг Таслах Актын мэдлийн асуудал мөн бөгөөд түүгээр зохицуулагдана, АНУ-ын ҮХ-ийн 9-р зүйл, 1-16-р хэсэг (ХХТА).

Тэмдэглэл: Та эдгээр Нөхцөлийг зөвшөөрснөөр Америкийн Нэгдсэн Улсаас гадуурх аливаа шүүх эрх мэдэл хэрэгжих газар нутгийн хуулийн дагуу SMG-ийн эсрэг таны гаргаж болох аливаа гомдол эсвэл үйлдэл хүчингүй болж буйг ил тодоор зөвшөөрч байгаа хэрэг мөн бөгөөд үүнд таны харьяалагддаг улсын хууль тогтоомжийн дагуух аливаа бүх гомдол эсвэл үйлдэл хамаарна., түүнчлэн таны цорын ганц байршил болон аливаа маргааныг зохицуулахад хэрэглэгдэх хууль нь 9-р бүлгийн нөхцөлийн дагуу Америкийн Нэгдсэн Улсын хууль байна гэдгийг та зөвшөөрч буй хэрэг юм.

10. ШАГНАЛ

Үе үе SMG танд шагналын оноо, үнийн хөнгөлөлт эсвэл тусгай санал гэх зэргийн шагнал авах боломжийг (хамтдаа холбогдон “**Шагнал**” гэж нэрлэгдэнэ) санал болгож болзошгүй. Та хэдийд SMG Services-ээр дамжуулан Шагнал авах боломжтой байгааг бид танд мэдэгдэх болно. Шагналын давуу талууд нь ялгаатай байж болохын зэрэгцээ хүчин төгөлдөр байх хугацаа нь ч ялгаатай байж болох тул Шагналаа авахдаа дэлгэрэнгүй мэдээллийг шалгаж байгаарай. SurveyMini-гийн хувьд идэвхжүүлэлгүй ер (90) хоног болоход таны шагналын оноо дуусах болно. Таны Шагнал таны хувийн хэрэглээнд зориулагдсан байна. Та Шагналаа шилжүүлэх, өгөх, зарах, солилцох боломжгүй. Хуулиар шаардаагүй бол Шагналыг бэлэн мөнгөөр сольж авах боломжгүй бөгөөд SMG эсвэл үйлчлүүлэгчийн өөр бусад ямар ч урамшуулал, санал, үнийн хөнгөлөлттэй нэгтгэх боломжгүй. Таныг Шагналаа авсаны дараа ямар ч зээл болон буцаан олголт хийгдэхгүй. SMG нь Шагналын хүртээмжтэй байдлыг өөрчлөх, таслан зогсоох, түр зогсоох эрхтэй. Та SMG-ийн Шагналтай холбоотой шийдвэрүүдийг даган мөрдөхийг зөвшөөрөх бөгөөд тэдгээр нь эцсийн шийдвэрүүд байна.

11. ГАР УТАСНЫ АППУУДЫН ШИНЭЧЛЭЛТ

Бид үе үе (өөрсдийн үзэмжээр) гар утасны програм буюу аппуудыг шинэчилж, шинэчилсэн хувилбаруудаар хангаж байх бөгөөд үүнд шинэчлэл, алдаа залруулалт, засалт болон өөр бусад алдаа залруулалт ба/эсвэл тохиргоо багтсан байна (хамтдаа холбогдон “**Updates**” гэж нэрлэгдэнэ). Түүнчлэн шинэчлэлтүүд нь тодорхой тохиргоо эсвэл ажиллах хэлбэрийг нь өөрчилж эсвэл бүхэлд нь устгаж болзошгүй. SMG нь таныг ямарваа нэгэн Шинэчлэлтээр хангах үүрэггүй, ямарваа нэгэн тодорхой тохиргоо эсвэл ажиллагааны хэлбэрээр хангасан хэвээр байх үүрэггүй болохыг та зөвшөөрнө.

Таны хөдөлгөөнт төхөөрөмж Интернетэд холбогдсон байхад таны хөдөлгөөнт төхөөрөмжийн тохиргооноос хамаараад нэг бол (а) Шинэчлэлтүүд автоматаар татагдаж суулгагдах болно; нэг бол (b) та Шинэчлэлтүүдийг татаж авч суулгах мэдэгдэл эсвэл сануулгыг хүлээн авах болно.

Бүх Шинэчлэлтүүдийг шурхай татаж авч суулга. Хэрэв та үүнийг хийхгүй байх аваас SMG Services-ийн зарим хэсэг зохих ёсоор ажиллахгүй байж болно. Цаашилбал, бүх Шинэчлэл нь SMG Services-ийн бүрэлдэхүүн хэсэгт тооцогдож, эдгээр Нөхцөлийн бүх заалт болон нөхцөлд захирагддаг болохыг та зөвшөөрнө.

12. ЦАХИМ ГЭРЭЭ

Та SMG Services-ийг хэрэглэхээр батласан ба / эсвэл түүнд бүртгүүлсэн бол та бидэнтэй цахим хэлбэрээр гэрээ байгуулахыг зөвшөөрсөн гэсэн үг юм.

13. ГАЗАР ЗҮЙН ХЯЗГААРЛАЛТ/ЭКСПОРТЫН ХЯНАЛТ

SMG Services ба SMG Контент нь Америкийн Нэгдсэн Улсын Миссури мужид байрладаг. Хэдийгээр аль алийг нь Америкийн Нэгдсэн Улсаас гадуур байгаа этгээдүүдэд олгох боломжтой ч гэлээ та хуулийн эсвэл ажиллагааны шалтгаанаар өөрийн шүүх эрх мэдэл хэрэгжих газар нутагтаа SMG Services ба SMG Контентод нэвтрэх боломжгүйг хүлээн зөвшөөрнө. Хэрэв та SMG Services ба SMG Контентод Америкийн Нэгдсэн Улсаар өөр газраас нэвтэрч байгаа бол та орон нутгийн хууль тогтоомж, үүнд мөн SMG Контентийн импорт, экспорт эсвэл давтан экспорттой холбоотой орон нутгийн хууль тогтоомийг даган мөрдөх үүрэгтэй.

Зарим орнуудын хувьд SMG нь АНУ-ын Экспортын Удирдлагын Акт болон түүнтэй холбоотой хууль тогтоомж гэх мэт экспортын хяналтын тухай хуулиудад захирагддаг. Та

ийм хууль тогтоомжийг даган мөрдөхийг зөвшөөрч, SMG services-ийг хууль тогтоомж, дүрэм журмаар нь экспортлох, дахин экспортлох болон гаргахыг хориглосон байдаг шүүх эрх мэдэл хэрэгжих газар нутаг эсвэл улс оронд SMG Services-ийг шууд эсвэл шууд бусаар экспортлохгүй, дахин экспортлохгүй, гаргахгүй / тийм улс орноос SMG Services авах боломжийг бий болгохгүй. Цаашилбал та SMG Services-ийг экспортлох, дахин экспортлох, гаргах эсвэл АНУ-ийн хил хязгаараас гадуур үзүүлэхээсээ өмнө холбооны холбогдох бүх хууль тогтоомж, дүрэм журмыг даган мөрдөж, шаардлагатай бүх үүргээ биелүүлэхийг (үүнд шаардлагатай экспортын лиценз эсвэл засгийн газрын өөр бусад зөвшөөрлийг авах зэрэг багтана) зөвшөөрнө. Үүнээс гадна та SMG Контентийг татаж авснаараа ийм экспортод хориг тавиагүй улс оронд байгаагаа, мөн АНУ-д байгаа бус болохоо хүлээн зөвшөөрнө. Арилжааны Хэлтсийн Захиалгаас Татгалзсан Татгалзлын Хүснэгт буюу АНУ-ын Сангийн Яамны Тусгайлан Экспорт Хийгдэх Улс Үндэстнүүдийн жагсаалт.

14. АНУ-ЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ЭРХ

SMG Services нь бол Холбооны Хэм Хэмжээний Актын Эмхэтгэлийн 48-р зүйлийн §2.101-д заасанчлан арилжааны компьютерийн программ хангамж юм. Иймд хэрэв танайх АНУ-ын Засгийн Газрын агентлаг эсвэл өөр бусад гэрээт байгууллага мөн бол бусад бүх хэрэглэгчдэд зөвхөн лицензээр олгогддог, (а) Батлан Хамгаалах Яам болон түүний гэрээт байгууллагуудын хувьд ХХХАЭ-ийн 48-ийн §227.7201 – ХХХАЭ-ийн 48-ийн §227.7204-ийн дагуу олгогддог, (b) АНУ-ын Засгийн Газрын бусад бүх лицензиатууд болон гэрээлэгчдийн хувьд ХХХАЭ-ийн 48-ийн §12.212-ийн дагуу олгогддог SMG Services-ийн эрхийг авна.

15. ЦУЦЛАЛТ

SMG нь өөрийн үзэмжээр танд мэдэгдэн эсвэл мэдэгдэлгүйгээр, ямар ч үед ямар ч шалтгаанаар, таны болон өөр бусад гуравдагч этгээдүүдийн өмнө ямарваа нэгэн үүрэг хүлээлгүйгээр SMG Services-ийг өөрчилж, үзүүлэхийг зогсоож, эсвэл таны бүртгэлийн данс эсвэл SMG Services-д нэвтрэх таны эрхийг өөрчилж, түр зогсоож эсвэл цуцалж болзошгүй. Жишээлбэл, хэрэв SMG-д таныг насанд хүрээгүй хүүхэд гэж итгэх шалтгаан байгаа бол танд урьдчилж мэдэгдэн эсвэл мэдэгдэлгүйгээр таны бүртгэлийн данс эсвэл SMG Services-д нэвтрэх боломжийг цуцалж болзошгүй. Өөр нэгэн жишээний хувьд, хэрэв SMG-д таныг худал, бүрэн бус эсвэл буруу мэдээлэл өгсөн, эсвэл эдгээр Нөхцөл эсвэл хэрэглэгдэх аливаа нэмэлт нөхцөлүүдийг даган мөрдөөгүй гэж үзэх шалтгаан байгаа бол танд урьдчилж мэдэгдэн эсвэл мэдэгдэлгүйгээр таны бүртгэлийн данс эсвэл SMG Services-ийг ашиглах боломжийг цуцалж болзошгүй.

Бид танаас хүссэн тохиолдолд та хийсэн Сайтын Материалуудын ямарч хуулбаруудаа буцаан өгөх эсвэл устгахыг зөвшөөрнө.

Цуцлалт нь SMG-ийн аливаа бусад эрх ба арга хэмжээг хязгаарлахгүй. Ийм өөрчлөлт, зогсоолт, түр зогсоолт ба / эсвэл цуцлалтаас үл хамааран эдгээр Нөхцөл нь хүчин төгөлдөр байдлаа хадгалж, үйлчилсэн хэвээрээ байх болно.

16. ЗОХИОГЧИЙН ЭРХИЙН ЗӨРЧЛИЙН ТУХАЙ МЭДЭГДЭЛ

SMG нь бусдын оюуны өмчийн эрхийг хүндэтгэн үздэг. Бид гарсан байж болзошгүй зөрчлийн тухай мэдэгдэлд АНУ-ын Цахим Эринд Зохиогчийн Эрхийг Хамгаалах Актын (“DMCA”) шаардлагын дагуу хариу өгдөг, үүнд мөн эрхийг зөрчиж байгаа зүйл хэмээн

мэдүүлэгдсэн материалд нэвтрэх боломжийг шаардлагатай тохиолдолд арилгах буюу хаадаг.

Хэрэв та SMG services-д эсвэл түүгээр дамжуулан таны ажил хуулбарлагдаж, зохиогчийн эрх зөрчигдөж эсвэл оюуны өмчийн эрх ямар нэгэн байдлаар зөрчигдсэн гэдэгт та бат итгэлтэй байгаа бол та манай МЭЗЭХА-ын агентлагт зөрчлийн тухай мэдэгдэл эсвэл өргөдөл гомдлоо дараах шуудангийн хаягаар илгээнэ:

DMCA Agent
Service Management Group, LLC
1737 McGee Street
Kansas City, MO 64108

Эсвэл дараах хаяг руу цахим захидал илгээнэ:

privacyofficer@smg.com

Таны мэдэгдэлд дараах мэдээлэл багтсан байх ёстой:

- a. зөрчигдсэн онцгой эрхийн эзэмшигчийн нэрийн өмнөөс үйлдэх эрх бүхий этгээдийн бодит эсвэл цахим гарын үсэг;
- b. зохиогчийн эрх нь зөрчигдсэн хэмээн мэдэгдсэн бүтээлийн тодорхойлолт, эсвэл нэг онлайн сайтан дээрх зохиогчийн эрх нь зөрчигдсэн хэд хэдэн бүтээлийн нэг мэдэгдлээр мэдэгдсэн тохиолдолд – тухайн сайтан дээрх тийм бүтээлүүдийг үзүүлсэн жагсаалт;
- c. эрхийг нь зөрчиж байгаа эсвэл зөрчих үйл ажиллагааны шалтгаан нь болж байгаа бөгөөд устгавал эсвэл түүнд нэвтрэх боломжийг нь хаавал зохих материалын тодорхойлолт, мөн үйлчилгээ үзүүлэгчид тухайн материалыг байршуулахад хангалттай үндэслэл болж чадах мэдээлэл;
- d. үйлчилгээ үзүүлэгч гомдол гаргагч талтай холбоо барихад хангалттай байх мэдээлэл, тухайлбал, хаяг, утасны дугаар, боломжтой бол гомдол гаргагч талтай холбогдох цахим шуудангийн хаяг;
- e. ийм байдлаар гомдол гаргагдсан материалын ашиглалт зохиогч, түүний төлөөлөгч эсвэл хуулиар зөвшөөрөөгүйд бат итгэлтэй байгаа тухай гомдол гаргагч талын мэдэгдэл; түүнчлэн
- f. мэдэгдэл дахь мэдээлэл нь үнэн бодит бөгөөд гомдол гаргагч тал худал мэдүүлэг өгөхөөс татгалзаж, зөрчигдсэн онцгой эрхийн эзэмшигчийн нэрийн өмнөөс үйлдэх бүрэн эрхтэй болох талаарх мэдүүлэг.

Манай ЦЭЗЭХА-ын Төлөөлөгч нь зөвхөн ЦЭЗЭХА-ын шаардлагыг хангасан мэдэгдэл ба нэхэмжлэлд хариу өгөх болно. Дэлгэрэнгүй мэдээлэл авах бол www.copyright.gov –г үзнэ үү.

17. КАЛИФОРНИЙН ОРШИН СУУГЧДАД ЗОРИУЛСАН МЭДЭЭЛЭЛ

Калифорнийн Иргэний хуулийн 1789.3-р зүйлд заасны дагуу бид Калифорнийн оршин суугчдад хэрэглэгчийн эрхийн талаарх дараах мэдээллийг олгох ёстой:

- a. SMG Services-ийг эзэмшигч ба / эсвэл эрхлэгч газар: Service Management Group LLC эзэмшдэг, 1737 McGee Street, Kansas City, MO 64108. SMG-тэй холбогдох утасны дугаар 1-800-764-0439;
- b. өөрөөр заагдаагүй тохиолдолд SMG Service нь үнэ төлбөргүй байна.

- c. SMG Services-ийн талаар гомдол гаргах эсвэл SMG Services-тэй холбоотой дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл Service Management Group LLC хаягаар захидал илгээнэ үү. Мэдээллийн нууцлал хамгаалалтын ажилтантай холбогдох хаяг: 1737 McGee Street, Kansas City, MO 64108 эсвэл privacyofficer@smg.com цахим шуудангаар (“Калифорнийн оршин суугчийн хүсэлт” гэсэн гарчигтайгаар) захидал илгээнэ үү. Түүнчлэн та Калифорнийн Хэрэглэгчдийн хэрэг эрхлэх газрын өргөдөл гомдол хэлэлцүүлэх хэлтэст бичгээр хандаж болно: 400 R Street, Suite 1080, Sacramento, California 95814, эсвэл 916.445.1254, 800.952.5210 утасны дугаараар холбогдож болно.

18. БУСАД

- a. Эдгээр Нөхцөл болон зохих сайтууд дээр дурдсан нууцлалын бодлогуудад SMG болон таны / хоорондын энэхүү бичиг баримтад агуулагдсан зүйлүүдийн талаарх бүрэн тайлбар агуулагдсан болно.
- b. Эдгээр Нөхцөлийг Англи хэл дээр бичсэн болно. Энэхүү Англи хэл дээрх Гэрээ нь давуу эрхтэй байна. Энэхүү Гэрээний аливаа бусад хэл дээрх хувилбарууд нь зөвхөн туслах үүрэгтэй бөгөөд тэдгээрийг аль нэг тал заавал биелүүлэх албагүй болно.
- c. Эдгээр Нөхцөл нь х SMG болон таны залгамжлагчид, томилогдогсод нарын эрх ашгийн төлөө тус тус үйлчлэх ба эдгээр нь Нөхцөлийг даган мөрдөнө.
- d. Эдгээр Нөхцөлийг SMG тогтоож болно. Харин та урьдчилан бичгээр мэдэгдэлгүйгээр тэдгээрийг тогтоох боломжгүй юм.
- e. Эдгээр Нөхцөлийн аль нэг заалт нь биелэгдэх боломжгүй эсвэл хүчин төгөлдөр бус болсон тохиолдолд бусад зүйл нь биелэгдэх боломжгүй эсвэл хүчин төгөлдөр бус зүйлүүд үйлчлэлтэй байсан үеийнх шиг хүчин төгөлдөр хэвээрээ байх болно.
- f. Хэрэв SMG болон та хоёрын аль нэг нь эдгээр Нөхцөлийн дагуух аливаа үүргээ биелүүлээгүй, харин нөгөө тал нь үүргээ биелүүлэхийг шаардаагүй бол үүргийн үл биелүүлэлт нь аливаа үүргээс чөлөөлөгдөх шалтгаан болохгүй бөгөөд бусад бүх тохиолдолд үүрэг биелүүлэхийг шаардахад саад учруулах ёсгүй.
- g. Энэхүү Нөхцөлд тодорхойлсон аливаа зүйл нь SMG ба таныг нэг нь нөгөөгийнхөө ажилтан эсвэл төлөөлөгч, хамтарсан үйлдвэрүүд эсвэл түншүүд болохыг илтгэхгүй.
- h. Хэрэв SMG эсвэл та ямар нэгэн хүндэтгэх шалтгаангүйгээр эдгээр Нөхцөлийн дагуух үүргээ гүйцэтгэж чадахгүй эсвэл гүйцэтгэх боломжгүй байгаа тохиолдолд эрх нь хөндөгдсөн тал ийм шалтгааны улмаас саатсан тэр хугацаагаар эсвэл гүйцэтгэх боломжгүй байгаа хугацаагаар гүйцэтгэлээ хойшлуулна.
- i. Гарчиг болон толгойг зөвхөн уншихад хялбар болгох үүднээс оруулсан болно.

АСУУЛТ БАЙНА УУ?

Хэрэв танд эдгээр Ашиглалтын Нөхцөл ба SMG Services-ийн талаар асуух асуулт байгаа бол privacyofficer@smg.com хаягаар бидэнтэй холбогдоно уу.

Та мөн бидэнд дараах хаягаар бичиж болно:

Service Management Group, LLC

Attn: Мэдээллийн нууцлал хамгаалалтын ажилтан

1737 McGee Street

Kansas City, MO 64108

®/ХТ худалдааны тэмдэг © Үйлчилгээний Удирдлагын Групп ХХК 2017. Бүх эрх хамгаалагдсан.